



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТОМУУГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



# *ТТӨ-ий дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ*

*А. БУРМАА, ХӨСҮТ, ТҮН-ИЙН ДАРГА,  
АУ-Ы ДОКТОР (PhD)*

*Томуугийн Үндэсний Есдүгээр Зөвлөлгөөн, Улаанбаатар хот, 2021-10-29*

# *АГУУЛГА*

*I. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо*

*II. ЭМС-ын томуугийн тандалттай холбоотойгоор мөрдөгдөж буй тушаал, журмууд*

*III. Томуугийн дархлаажуулалт*

*IV. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ*

***I. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо***

*II. ЭМС-ын томуугийн тандалттай холбоотойгоор мөрдөгдөж буй тушаал, журмууд*

*III. Томуугийн дархлаажуулалт*

*IV. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ*

# Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо

Амбулаторид суурилсан ТХТН:115


- I зэрэглэл - 61
- II зэрэглэл - 54

Эмнэлэгт суурилсан ТХТН:37

- I зэрэглэл - 17
- II зэрэглэл – 20

Лабораторид суурилсан тандалт

ХӨСҮТ-ийн ВС-ын лавлагаа лаборатори, 21 аймгийн молекул-биологийн лаборатори



# ***ЗОРИЛГО***

- ▶ Тандалт нь дэгдэлтийг эрт илрүүлэх, түргэвчилсэн үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулах, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.

Томуу, томуу төст өвчин (ТТӨ), амьсгалын замын цочмог хүнд халдвар (АЗЦХХ)-ын тандалт нь ТТӨ-ий эпидемиологийн болон вируслогийн шинж төрхийг тодорхойлж, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах үүрэгтэй.

# *Тохиолдлын тодорхойлолт*

- ▶ Сүүлийн 10 хоногт гэнэт 38°C хэм, түүнээс дээш өндөр халуурах, ханиалгах зэрэг эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн амьсгалын замын цочмог халдварын тохиолдлыг **“томуу, томуу төст өвчин”**;
- ▶ Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг бүхий эмнэлэгт хэвтэх шаардлагатай тохиолдлыг **“амьсгалын замын хүнд халдвар”**;
- ▶ Нэг хамтлаг, хамт олны дунд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд эмнэлзүйн адил шинж тэмдэг гэнэт илрэхийг **“голомтолсон өвчлөл”** гэж тус тус үзнэ.

*I. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо*

***II. ЭМС-ын томуугийн тандалттай холбоотойгоор мөрдөгдөж буй тушаал, журмууд***

*III. Томуугийн дархлаажуулалт*

*IV. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ*

***Томуу, томуу төст өвчний харуулдан  
тандалтын тогтолцоог  
өргөжүүлэх тухай***

**2014 оны ЭМС-ын 358 тоот тушаал**



# *Тушаалын бүтэц*

Хавсралт 1: Томуугийн харуулдан тандалтын удирдамж

Хавсралт 2: Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдээс мэдээ авах маягт

*Хавсралт 3: Томуу, томуу төст өвчний улирал угтуулж болон дэгдэлтийн үед авах арга хэмжээний журам*

Хавсралт 4: Томуугийн харуулдан тандалтын сорьц авах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх журам

Хавсралт 5: Томуугийн тандалтын тогтвортой хөгжлийн төлөвлөгөө

Хавсралт 6: Томуугийн харуулдан тандалтын I, II зэрэглэлийн нэгжийн жагсаалт

# *ТТӨ-ий улирал угтуулж болон дэгдэлтийн үед авах арга хэмжээний журам*

1. ХӨСҮТ-ийн ТҮТ-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл
2. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, засаг захиргааны нэгжүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл
  - ТТӨ амбулаторийн нийт үзлэгийн 4 хүртэлх хувь
  - ТТӨ амбулаторийн нийт үзлэгийн 5-9 хүртэлх хувь
  - ТТӨ амбулаторийн нийт үзлэгийн 10-15 хүртэлх хувь
  - ТТӨ амбулаторийн нийт үзлэгийн 15< хувь
3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн болон хүүхдийн байгууллагуудын хэрэгжүүлэх арга хэмжээ

***Томуу, томуу төст өвчний бэлэн  
байдал, хариу арга хэмжээний  
удирдамж батлах тухай***

2020 оны ЭМС-ын А/482 тоот тушаал

# *Тушаалын бүтэц*

2 хавсралттай:

- ▶ Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж
- ▶ Мэдээ авах маягтууд

## *Зорилго*

- ▶ ТТӨ-ий тархалтын үе шатыг ДЭМБ-ын зөвлөмж болгосон аргачлалын дагуу үнэлж, тархалтын үе шат бүрт тохирсон эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад оршино.

## *Зорилт*

- ▶ ТТӨ-ий тархалтын үе шат бүрт тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- ▶ ТТӨ-ий тархалтын үе шат бүрт бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах;

# *Тохиолдлын тодорхойлолт*

- ▶ ТТӨ
- ▶ АЗЦХХ

*Өвчний олон улсын X ангилал: J00-J22*

## *Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үе шатыг үнэлэх*

- ▶ ТТӨ-ий тархалтын үе шатыг тодорхойлохдоо амбулаторийн үзлэгт *ТТӨ-ий 10,000 хүн ам дах өвчлөл, 16 нас хүртэлх хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн дундах амьсгалын замын цочмог хүнд халдварын эзлэх хувийг* харьцуулан тархалтын түвшнийг ХӨСҮТ-өөс 7 хоног тутам тогтооно.
- ▶ Үнэлгээний матрицыг ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын тушаалын дагуу жил бүр тодотгон, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Амбулаторийн үзлэг, амьсгалын замын цочмог хүнд халдварын босго үзүүлэлт

Үе шат	Амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчний 10,000 хүн ам дахь өвчлөл	16 хүртэлх насны эмнэлэгт хэвтэгсдийн дунд амьсгалын замын цочмог хүнд халдварын эзлэх хувь
Улирал хоорондын үе (ногоон)	<22.6	<44%
Идэвхжлийн үе (шар)	22.7-36	45%-56%
Алаг цоог дэгдэлт (улбар шар)	37-70	57%-69%
Улсын хэмжээний дэгдэлт (улаан)	71-107	70%-82%
Тахалт тархалт (ягаан)	>108	>83%





# Тархалтын үе шатыг үнэлэх матриц

Үзүүлэлт		Тархалтын зэрэг (ТТӨ 10000 хүн амд)					
		<22.6	22.7-36	37-70	71-107	>108	
		Улирал хооронд	Идэвхжилийн үе	Алаг цоог	Аймгийн хэмжээний	Тахал тархалт	
Үр нөлөө (16 хүртэлх насны эмнэлэгт хэвтэгсдийн дунд АЗЦХХ-ын эзлэх хувь)	<44%	Улирал хооронд					
	44%-56%	Идэвхжилийн үе					
	57%-69%	Алаг цоог					
	70%-82%	Аймгийн хэмжээний					
	>83%	Тахал тархалт					

# Тархалтын үе шат

*Томуугийн цартахал болон улирлын томуугийн хүндрэлийн үнэлгээгээр:*

- ▶ Тахалт тархалтын босго үзүүлэлтээс 1 долоо хоног давсан тохиолдол нь **тахалт тархалтын үе**;
- ▶ Улсын хэмжээний дэгдэлтийн босго үзүүлэлтээс 1 долоо хоног давсан тохиолдол нь **улсын хэмжээний дэгдэлтийн үе**;
- ▶ Алаг цоог дэгдэлтийн босго үзүүлэлтээс 2 долоо хоног дараалан давсан тохиолдол нь **алаг цоог дэгдэлтийн үе**;
- ▶ Томуугийн улирлын босго үзүүлэлтээс 2 долоо хоног дараалан давсан тохиолдол нь **идэвхжлийн үе**;
- ▶ Улирал хоорондын босго үзүүлэлтээс 2 долоо хоног дараалан буурсан тохиолдол нь **улирал хоорондын үе** эхэлснийг тус тус тодорхойлно.



## ТТӨ-ий идэвхжил, алаг цоог дэгдэлтийн үед

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ АМЬСГАЛЫН ЗАМЫН ЦОЧМОГ ХҮНД ХАЛДВАРЫГ МЭДЭЭЛЭХ МАЯГТ

Маягт 1. Томуу, томуу төст өвчний идэвхжлийн болон алаг цоог дэгдэлтийн үеийн мэдээний маягт

Он/сар/өдөр: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_ Долоо хоног: \_\_\_\_\_  
 Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_  
 Эрчимт эмчилгээний тасагт байгаа амьсгалын замын цочмог хүнд халдвартай хүний тоо: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_  
 Намалтээр зохицуулсан орны тоо /бусад тасгаас/: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_ Эрчимт эмчилгээ: \_\_\_\_\_  
 Намалтээр дэлгэсэн орны тоо: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_ Эрчимт эмчилгээ: \_\_\_\_\_

## ТТӨ-ий тахалт тархалтын үед

Маягт 3. Томуу, томуу төст өвчний тахалт тархалтын үеийн мэдээний маягт

Он/сар/өдөр: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_

	Нийт	Жирэмсэн	Насны ангиллаар					
			1 хуртан	1-4	5-10	20-64	65+	
Одоо байгаа өвчтөний тоо								
Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдвар								
Шинээр амьсгалт эвгэсэн хүний тоо								
Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдвар								
Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо								
Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдвар								
Наралтай тусламжийн тасгаар үйлчлүүлсэн хүний тоо								
Үүнээс: Томуу, томуу төст өвчний амьсгалын замын цочмог хүнд халдвар								

Намалтээр зохицуулсан орны тоо /бусад тасгаас/: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_ Эрчимт эмчилгээ: \_\_\_\_\_  
 Намалтээр дэлгэсэн орны тоо: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_ Эрчимт эмчилгээ: \_\_\_\_\_

## ТТӨ-ий улсын хэмжээний дэгдэлтийн үед

Маягт 2. Дэгдэлтийн үеийн мэдээний маягт

Он/сар/өдөр: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_  
 Одоо байгаа өвчтөний тоо: \_\_\_\_\_ Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_  
 Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдвар:  
 Нийт: \_\_\_\_\_ Хүүхэд: \_\_\_\_\_  
 Том хун\*: \_\_\_\_\_ Жирэмсэн эмэгтэй: \_\_\_\_\_  
 Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо: \_\_\_\_\_ Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_  
 Үүнээс: Амьсгалын замын цочмог хүнд халдвар:  
 Нийт: \_\_\_\_\_ Хүүхэд: \_\_\_\_\_  
 Том хун\*: \_\_\_\_\_ Жирэмсэн эмэгтэй: \_\_\_\_\_  
 Наралтай тусламжийн тасгаар үйлчлүүлсэн хүний тоо:  
 Хэвтсэн: \_\_\_\_\_ Гэрээр буцсан: \_\_\_\_\_  
 Үүнээс: Томуу, томуу төст өвчний амьсгалын замын цочмог хүнд халдвар:  
 Хэвтсэн: \_\_\_\_\_ Гэрээр буцсан: \_\_\_\_\_  
 Намалтээр зохицуулсан орны тоо /бусад тасгаас/: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_ Эрчимт эмчилгээ: \_\_\_\_\_  
 Намалтээр дэлгэсэн орны тоо: \_\_\_\_\_  
 Үүнээс хүүхэд: \_\_\_\_\_ Насанд хургаад: \_\_\_\_\_ Эрчимт эмчилгээ: \_\_\_\_\_

## АЗЦХХ-ын үед

Маягт 4. Амьсгалын замын цочмог хүнд халдварын нас баралт мэдээлэх маягт

Мэдээлсэн огноо: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_  
 Эмнэлгийн нэр: \_\_\_\_\_  
 Мэдээлсэн хүний нэр, албан тушаал: \_\_\_\_\_  
 Өвчтөний овог, нэр: \_\_\_\_\_  
 Төрсөн огноо: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_ Нас: \_\_\_\_\_ Хүйс: \_\_\_\_\_  
 Өвчин эхэлсэн огноо: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_  
 Эмнэлэгт хэвтсэн огноо: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_  
 Нас барсан огноо: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_  
 Үндсэн онош (ICD 10): \_\_\_\_\_  
 Хавсарсан онош: \_\_\_\_\_  
 Архаг суурь өвчтөнтэй эсэх  Тийм  Үгүй  
 Тийм бол онош: \_\_\_\_\_  
 Вирусийн эсрэг эмчилгээ хийгдсэн эсэх  Тийм  Үгүй  
 Тийм бол хугацаа (хоног, цаг): \_\_\_\_\_  
 Томуугийн сорьц өгсөн эсэх  Тийм  Үгүй  
 Тийм бол огноо: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_ хариу: \_\_\_\_\_  
 Эвдлэн эхлэсэн эсэх  Тийм  Үгүй  
 Тийм бол огноо: \_\_\_\_ / \_\_\_\_ / \_\_\_\_ онош: \_\_\_\_\_

# *Эрүүл мэндийн байгууллагуудаас авч хэрэгжүүлэх харцу арга хэмжээ*

- ▶ ЭМЯ
- ▶ ХӨСҮТ
- ▶ АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

## Түр заавар батлах тухай

Хүснэгт 1. Томуугийн харуулдан тандалтын нэмэлт нэгжүүд

№	Нэгжийн нэр	Сум, хилийн боомт	Сорьц хүргэх лаборатори
Нэг. Хилийн боомт			
1	Баян-Өлгий	Цагааннуур, Цагааннуур	Ховд аймаг
2	Дорноговь	Замын-Үүд, Замын-Үүд Хатанбулаг, Ханги	Замын-Үүд сум
3	Дорнод	Чойбалсан, Хавирга Чулуунхороот, Эрэнцав Халхгол, Баянхошуу	Дорнод аймаг
4	Өмнөговь	Ханбогд, Гашуунсухайт Гурвантэс, Шивээхүрэн	Улаанбаатар
5	Сүхбаатар	Эрдэнэцагаан, Бичигт	Улаанбаатар
6	Сэлэнгэ	Алтанбулаг, Алтанбулаг Сүхбаатар, Сүхбаатар	Сэлэнгэ аймаг
7	Увс	Давст, Боршоо	Ховд аймаг
8	Ховд	Булган, Булган	Ховд аймаг
9	Хөвсгөл	Ханх, Ханх	Улаанбаатар
2. Эрүүл мэндийн байгууллага			
1	Улсын хоёрдугаар төв эмнэлэг		ХӨСҮТ, ВСЛ
2	Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг		ХӨСҮТ, ВСЛ
3	Цэргийн төв эмнэлэг		ХӨСҮТ, ВСЛ
4	Улаанбаатар төмөр замын төв эмнэлэг		ХӨСҮТ, ВСЛ
3. Амаржих газар			
5	Өргөө		ХӨСҮТ, ВСЛ
6	Хүрээ		ХӨСҮТ, ВСЛ
7	Амгалан		ХӨСҮТ, ВСЛ

**“Томуугийн одоогийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилан коронавируст халдварын тандалтыг өргөжүүлэх” ЭМС-ын 2020 оны 583 тоот тушаалаар нэмэгдүүлсэн тандалтын нэгж**

ЭМС-ын 2020 оны А/583 тоот тушаал

*Томуугийн цартахлын бэлэн  
байдал, хариу арга хэмжээний  
удирдамж батлах тухай*

2018 оны ЭМС-ын А/438 тоот тушаал

# *Тушаалын бүтэц*

3 хавсралттай:

- Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж
- Томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө /2018-2022/
- Томуугийн цартахлын вируст халдварын тархвар судалгааны хуудас

## ***Зорилго***

- ▶ Томуугийн цартахал болон шинэ вируст халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган хохирол багатай даван туулах арга хэмжээг зохион байгуулах.

## ***Зорилт***

- ▶ Томуугийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх, томуугийн цартахал болон шинэ вируст халдварыг шуурхай илрүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах.
- ▶ Цартахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, тасралтгүй хүргэх, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх.
- ▶ Цартахлын үед хүн амыг цартахлын вакцинаар шуурхай дархлаажуулах, хүн ам, иргэдийн оролцоог дэмжих замаар халдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах, хязгаарлах.
- ▶ Хүн ам, ард иргэдийг үнэн зөв, бодит мэдээллээр шуурхай хангах.



# Цартахлын үе шат

<i>Үе шат</i>	<i>Тодорхойлолт</i>
Цартахал хоорондын үе	Томуугийн вирус амьтны популяцид давамгайлан орчилд орсон байна. Хүнд халдварлах нь ховор.
Цартахлын түгшүүр үе	Шинэ вирус хүнээс хүнд дамжин халдварлах чадвартай болно. Томуугийн шинэ вируст хүний халдвар бүртгэгдэж эхэлнэ.
Цартахлын үе	Шинэ вирус хүн амын дунд өргөн тархаж, хүнээс хүнд дамжин халдварлана. Томуугийн шинэ вирус дэлхий дахинд тархаж, хүн амыг олноор өвчлүүлнэ.
Цартахлын дараах үе	Шинэ вируст халдварын тархалт буурч, ердийн түвшинд хүрнэ. Халдвар эсэргүйцэх арга хэмжээний хүрээг хумьж, нөхөн сэргээх арга хэмжээг авч эхэлнэ.

# *Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэх үүрэг*

- ▶ ЭМЯ
- ▶ ХӨСҮТ
- ▶ ЭМБ-ууд

# *Томуугийн цартахал болон шинэ вируст халдварын үеийн хариу арга хэмжээ*

1. Эрсдэлийн үнэлгээ
2. Тандалт, судалгаа
3. Лабораторийн тандалт
4. Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ
5. Эрсдэлийн үеийн харилцаа холбоо
6. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмчилгээ
7. Халдварын сэргийлэлт, хяналт (үе шат тус бүрээр, ялангуяа цартахлын үеийн тусгаарлан сэргийлэлт, өвчтөнийг шилжүүлэх, тээвэрлэх, ХХХ, эмгэг судлалын шинжилгээ хийх, оршуулах үед баримтлах дэглэм зэргийг тодорхой тусгаж өгсөн)
8. Хариу арга хэмжээний үнэлгээ

# *Цартахлын үеийн бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар*

№	Цартахлын үе шат	Тодорхойлолт	Үйл ажиллагаа
1	Цартахлын өмнөх үе	Дэлхийн аль нэг улс оронд томуугийн шинэ вируст хүний халдвар бүртгэгдсэн (амьтдын популяцад давамгайлсан орчилд байх ба хүнээс хүнд дамжин халдварлаагүй).	<ul style="list-style-type: none"> <li>• Тандалт судалгааг эрчимжүүлнэ.</li> <li>• Халдвар бүртгэгдсэн бүс нутгийн нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг цуглуулна.</li> <li>• Эрсдэлийн үеийн харилцаа холбоог сайжруулна.</li> </ul>
2	Цартахлын түгшүүр үе	Дэлхийн аль нэг улс оронд томуугийн шинэ вируст халдвар хүнээс хүнд дамжсан халдварласан тохиолдол бүртгэгдсэн.	<ul style="list-style-type: none"> <li>• Тандалт судалгааг эрчимжүүлнэ.</li> <li>• Эрсдэлийн үнэлгээ хийнэ.</li> <li>• Лабораторийн оношилгоог сайжруулна.</li> <li>• Урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааг эрчимжүүлнэ.</li> <li>• Цартахлын вирүсийн халдварын эсрэг вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах төлөвлөгөөг гаргана.</li> <li>• Цартахлын үеийн бэлэн, байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу бэлэн байдлыг хангана.</li> </ul>

№	Цартахлын үе шат	Тодорхойлолт	Үйл ажиллагаа
3	Цартахлын үе	Томуугийн шинэ вируст халдварын хүний өвчлөлийн эхний тохиолдол бүртгэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Цартахлын түгшүүр үеийн арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.</li> <li>Цартахлын үеийн бэлэн, байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөг идэвхжүүлнэ.</li> <li>Тархвар судлал, эмнэлзүйн шинж төрхийн талаарх тандалт судалгааг нарийвчлан хийж, эрсдэлийн үнэлгээ хийнэ.</li> <li>Эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэн, эрүүл мэндийн байгууллагад хүргүүлнэ.</li> </ul>
4		Томуугийн шинэ вируст халдварын хүний өвчлөлийн хэд хэдэн тохиолдол бүртгэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Цартахлын үеийн бэлэн, байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</li> <li>Эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулна.</li> <li>Тохиолдлын тоо нэмэгдэж байгаа үед нэмэлт ор, эмнэлэг дэлгэх арга хэмжээг зохион байгуулна.</li> <li>Нийтийг хамарсан хязгаарлалтын арга хэмжээг авч эхлэх (сургууль, цэцэрлэгийг хаах, үйлчилгээний байгууллагын цагийг богиносгох, хаах гэх мэт).</li> <li>Цартахлын вирүсийн халдварын эсрэг вакциныг шуурхай түгээх, дархлаажуулах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</li> <li>Цартахлын тархварзүйн болон вирүсийн онцлогийг тандан судалж, дүгнэлт гаргана.</li> <li>Эрсдэлийн түвшинд тохирсон эрсдэлийн харилцаа холбооны арга хэмжээг хэрэгжүүлнэ.</li> </ul>

№	Цартахлын үе шат	Тодорхойлолт	Үйл ажиллагаа
5	Цартахлын үе	Томуугийн шинэ вируст халдварын хүний өвчлөл тогтвортой тархана.	<p>Цартахлын үеийн бэлэн, байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнг хэрэгцээгээр нь эрэмбэлэн ангилна (жирэмсний үзлэг, хяналт, товллын дархлаажуулалт зэрэг амбулаториор үзүүлэх тусламж үйлчилгээ гэх мэт).</li> <li>• Эрүүл мэндийн байгууллагын нягтралыг бууруулна.</li> <li>• Олон нийтийн үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээ авна.</li> <li>• Хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахим болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өдөр бүр хийнэ.</li> </ul>
6	Цартахлын дараах үе	Томуугийн шинэ вируст халдварын хүний өвчлөлийн эрч буурч, алаг цоог хэлбэрээр бүртгэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Томуугийн цартахлын дараагийн давалгаанд бэлтгэнэ.</li> <li>• Дараагийн цартахлын давалгаанд шаардлагатай нөөц бүрдүүлнэ.</li> <li>• Хэрэгжүүлсэн хариу арга хэмжээг үнэлэн, төлөвлөгөөнд тодотгол хийнэ.</li> <li>• Вакцины нөөцийг шинээр бүрдүүлнэ.</li> <li>• Дараагийн давалгааг эрт илрүүлэх тандалтыг идэвхтэй хийнэ.</li> <li>• Нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулна.</li> </ul>

*I. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо*

*II. ЭМС-ын томуугийн тандалттай холбоотойгоор мөрдөгдөж буй тушаал, журмууд*

***III. Томуугийн дархлаажуулалт***

*IV. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ*

# Томуугийн дархлаажуулалт





# Risk groups: SAGE recommendations


*Vaccines against influenza: WHO position paper – November 2012*

“For countries considering the initiation or expansion of programmes for seasonal influenza vaccination, WHO recommends that **pregnant women** should have the **highest priority**. Additional risk groups to be considered for vaccination, in no particular order of priority, are **children aged 6–59 months**, the **elderly**, individuals with **specific chronic medical conditions**, and **health-care workers**.”


\* WHO. Wkly Epidemiol Rec. No. 47, 2012, 87, 461–476.



# Улирлын томуугийн дархлаажуулалт




Томуугийн дархлаажуулалт



Жирэмсэн эмэгтэйчүүд

# ТОМУУГИЙН ДАРХЛААЖУУЛАЛТ




*I. Томуугийн харуулдан тандалтын тогтолцоо*

*II. ЭМС-ын томуугийн тандалттай холбоотойгоор мөрдөгдөж буй тушаал, журмууд*


*III. Томуугийн дархлаажуулалт*

***IV. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ***

- ▶ КОВИД-19 халдвар тандалтыг ТТӨ-ий тандалтын тогтолцоотой уялдуулж өргөтгөх зорилгоор ЭМС-ын тушаалыг шинэчлэн, батлуулах (358, А/583, А/482 тоот тушаал);
- ▶ Өвөрхангай, Сэлэнгэ, Дорноговь аймагт вирус судлалын салбар лабораториудад КОВИД-19-аас гадна ТТӨ-ий вирус шинжлэх нөхцлийг бүрдүүлж, тандалтыг өргөжүүлэх;
- ▶ Улирлын томуугийн болон цартахлын эрсдэлийн үнэлгээг аймаг, нийслэлийн түвшинд нэвтрүүлэх;
- ▶ Вирус судлалын тандалтыг идэвхжүүлэх, ялангуяа 4 хүртэлх насны хүүхдэд ТТӨ-ий шинж тэмдэг илэрсэн тохиолдолд сорьц авч лабораторид хүргүүлэх;
- ▶ Томуугийн вирус, АЗСВ орчилд орсон тохиолдолд түргэвчилсэн тест хэрэглэх боломжийг судалж, нөөцийг бүрдүүлэх;
- ▶ ТХТН-үүдэд дэмжлэгт хяналт хийх, ажлын байран дахь сургалтыг тогтмол, давтамжтайгаар зохион байгуулах, эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах;
- ▶ Эрсдэлт бүлгийн хүн ам, ялангуяа жирэмсэн эхчүүдийн томуугийн вакцинд хамрагдалтыг нэмэгдүүлэх;



# *Анхаарал хандуулсанд баярлалаа*



**Influenza  
Virus**

© sheshaime.com